




# 2019 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

"Оюу толгой" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулав





**Аюулгүй ажиллагааг хангах нь “Оюу толгой” компанийн нэн тэргүүний зорилт билээ. Эрсдэлтэй ямар ч ажлыг шууд зогсооно.**




# Гарчиг

Оны товчоон	6
Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ	8
Гүйцэтгэх захирал, Гүний уурхайн төслийн захирлын мэндчилгээ	10
Компанийн тухай	12
Алсын хараа, манай ирээдүй	13
Санхүүгийн гүйцэтгэл	16
Зохистой зарцуулалтын арга хэмжээ	18
Худалдан авалт, хангамжийн сүлжээ	19
Аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд болон байгаль орчин	22
Дэлхийд өрсөлдөхүйц үйлдвэрлэл	28
Мэргэшсэн ажиллах хүчин	29
Түншлэгч талуудын хамтын ажиллагаа	30
Стратегийн хөгжил	36
Төлөөлөн удирдах зөвлөл	42
Гүйцэтгэх удирдлагын баг	43
ТУЗ ба Хувьцаа эзэмшигчдийн хурал	44

# ОНЫ ТОВЧООН<sup>1</sup>

## Бүх гэмтэл бэртлийн давтамж (БГБД)


(200,000 хүн/цаг)



"Оюу толгой" компани 2019 онд аюулгүй ажиллагааны өндөр гүйцэтгэлтэй ажиллаж, 200,000 хүн/цагт ногдох бүх гэмтэл, бэртлийн давтамж (БГБД)-ийг 0.16 болтол бууруулсан нь компанийн түүхэн дэх хамгийн өндөр амжилт болж байна.

## Баяжмал үйлдвэрлэл


(мян.тонн, хуурай жингээр)



Гүний уурхайн хүдэр боловсруулж эхлэх хугацаа хойшилсонтой холбоотой алдагдлыг ил уурхайн агуулга багатай хүдрээр нөхөх шаардлагатай болсон. Ингэснээр үйлдвэрлэсэн баяжмалын хэмжээ 2018 оныхоос буурсан ч металл авалтын хэмжээг 2018 оныхтой ижил түвшинд барьж чадлаа.

## Баяжмалын борлуулалт


(мян.тонн, хуурай жингээр)



Үйлдвэрлэсэн баяжмалын хэмжээ буурсантай холбоотойгоор борлуулсан баяжмалын хэмжээ 2018 оныхоос бага байв. 2018 оны 12 дугаар сараас хилийн боомт дээр үүссэн түгжрэл саатал 2019 онд бүрэн арилснаар баяжмалын тээвэрлэлт, худалдан авагчдын татан авалт сайжирч, агуулахад хуримтлагдаад байсан баяжмалыг 2019 оны эхний хагаст борлуулж дуусгасан.

## Урсгал капитал


(сая ам.доллараар)



2019 онд урсгал капиталын зардал 2018 оныхоос 43 сая ам.доллараар их байв. Уг өсөлт нь ил уурхайн олборлолт 6В үе шатанд шилжиж хөрсний тээвэрлэлт нэмэгдэн, хөрс хуулалтыг хойшлуулсны капитал зардал 29 сая ам.доллараар, мөн хаягдал хадгалах байгууламжийн барилгын зардал 5 сая ам.доллараар тус тус өссөнөөс голлон шалтгаалсан.

## Бүтээн байгуулалтын капитал


(сая ам.доллараар)



Газрын гадарга дээрх дэд бүтцийн зарим томоохон байгууламжуудыг барьж дууссантай холбоотойгоор бүтээн байгуулалтын капитал зардал 2018 оныхоос бага зэрэг буурсан.

## Барилгын ажлын явц


(хувиар)



"Үйлдвэрлэл ам"-ны бүтээн байгуулалтыг дуусгаж, зарим томоохон барилга байгууламжуудыг (Дулааны төв станц, Уурхайн захиргаа, үйлчилгээний "Чандмань" төв, Гүний уурхайн агаар халаах байгууламж) ашиглалтад оруулав.

<sup>1</sup> Санхүүгийн хураангуйлсан үзүүлэлтүүдийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу боловсруулан гаргасан "Оюу толгой" ХХК-ийн 2015, 2016, 2017, 2018, 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдлын аудитаар баталгаажсан тайлангаас авсан болно. Аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг боловсруулахдаа "Оюу толгой" компанийг бие даасан бизнесийн нэгжийн түвшинд авч үзсэн бөгөөд уг тайланд тусгасан мэдээлэл нь дүнгийн тохируулах бичилт, нягтлан бодох бүртгэлийн бусад ялгаанаас шалтгаалд "Туркойз Хилл Ресурс" болон "Рио Тинто"-ийн тайланд тусгасан мэдээллээс зөрүүтэй байж болохыг анхаарна уу.


### Татвар, хураамж, бусад төлбөр (2010-2019) (сая ам.доллар)



2010 - 2019 оны хооронд 2.6 тэрбум ам.долларыг Монгол Улсын татвар, хураамж, дотоодын компаниудад төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт төлсөн ба 2019 онд татвар, хураамж болон бусад төлбөрт 321 сая ам.доллар төлжээ.


\* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

### Дотоодод зарцуулсан нийт мөнгөн хөрөнгө (2010-2019) (тэрбум ам.доллар)




2010-2019 оны хооронд дотоодын компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалин 10.3 тэрбум ам.доллар давлаа.

### Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалт (2010-2019) (сая ам.доллар)



2019 онд Өмнөговь аймагт бүртгэлтэй 87 ханган нийлүүлэгч "Оюу толгой" компанид бараа, үйлчилгээ нийлүүлэв. 2010-2019 онд Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалтад нийт 554 сая ам.доллар зарцуулжээ.


### Үндэсний худалдан авалт (2010-2019) (сая ам.доллар, жилээр)



2019 онд үйл ажиллагааны худалдан авалтын баг 838 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 564 нь үндэсний компаниуд байв. Нийт худалдан авалтынхаа 76 хувийг эдгээр үндэсний компаниудад зарцуулав. 2010-2019 онд 3.1 тэрбум долларыг үндэсний худалдан авалтад зарцуулжээ.

### Усны хэрэглээ


(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)



Нэг тонн хүдэр боловсруулахдаа 0.4м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

### Ус дахин ашиглалт

(Зорилт - 80 хувь)



2019 онд зорилтоо давуулан биелүүлж, ус дахин ашиглалтын түвшинг дунджаар 87 хувьд хүргэв.

# Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ



**“Оюу толгой” компани нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа аюул осолгүй, тогтвортой үргэлжлүүлж, гүний уурхайн бүтээн байгуулалтаа улам эрчимжүүлсэн нэгэн оныг үдсэн амжилтыг хуваалцах завшаан олдсонд нэн баяртай байна. Өнгөрсөн хугацаанд амжилт олохын сацуу сорилт бэрхшээлтэй тулгарч ирсэн хэдий ч манай хамт олон 2019 онд дэлхийн түвшний зэсийн уурхайн найдвартай ирээдүйн үндэс суурийг тавих чиглэлд олон чухал алхам хийсэн болно.**

Өнгөрсөн онд Оюу толгой-Ханбогд чиглэлийн авто зам барьж ашиглалтад оруулсан нь Өмнөговь аймаг, түншлэгч сумдын тогтвортой хөгжил, хүн ардын сайн сайхан амьдралын төлөө хийсэн цөөнгүй бүтээн байгуулалтын маань нэг. Олон улсын стандартад нийцсэн 35 км урттай энэхүү зам нь Өмнийн говийн хувьд байгаль орчин, археологи, соёлын өвд ээлтэй байх зарчмыг хангасан орчин үеийн жишиг бүтээн байгуулалт болсон юм.

Энэхүү зам нь Ханбогд сумын хувьд бие дааж тогтвортой хөгжих чадамжтай суурин болж өргөжих суурийг бүрдүүлээд зогсохгүй тус сумын цаашдын хөгжлийн мастер төлөвлөгөөг шинэчлэх шаардлагыг гаргаж тавилаа. Үүнтэй уялдуулж тус компанийн зүгээс Ханбогд сумын дунд ба урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогын цогц баримт бичиг боловсруулах зорилго тавьж Барилга, хот байгуулалтын яам, Өмнөговь аймаг болон Ханбогд сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллав. Энэ ажлын хүрээнд уг сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг 2020 оны дунд гэхэд шинэчилж дуусгах болно.

Түүнчлэн уурхайн захиргаа, үйлчилгээний “Чандмань” төв болон “Үйлдвэрлэлийн ам”-ыг барьж дуусгасан бөгөөд эдгээр нь гүний уурхайн бүтээн байгуулалтад нэн чухал үүрэгтэй дэд бүтцийн байгууламж юм.

Манай компанийн хувьд ажилчдын аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан орших асуудлыг ямагт чухалчлан анхаардаг. Тийм учраас уурхайн цогцолборт тав тухтай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх чиглэлд олон төрлийн ажил санаачлан хэрэгжүүлснээс гадна түүний тохижилтыг дунд болоод урт хугацаанд сайжруулж хөгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж байгаа болно.

Цагдаагийн ерөнхий газартай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн “Яараад яахав дээ”, “Дураараа биш дүрмээрээ” хэмээх хоёр төрлийн аяныг амжилттай зохион байгуулав.

Эдгээр аяны үр дүнг 2018 оныхтой харьцуулахад зам тээврийн осол улсын хэмжээнд 63.9 хувь, Улаанбаатар хотод 16.3 хувиар тус тус буурчээ. Манай энэхүү санаачилга нь компанийнхаа аюулгүй ажиллагааны соёлыг хуваалцах замаар нийгэмд эерэг өөрчлөлт төрүүлэхэд чиглэсэн эхний алхам бөгөөд цаашид ч үргэлжлэн хэрэгжих болно.



Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, дэлхийд алдаршсан геологич Д. Гарамжав агсны гавьяат үйлсийг мөнхлөх зорилгоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу ил уурхайг түүний нэрэмжит болгосон юм.

Томоохон компаниудын хувьд хувьцаа эзэмшигчдийн харилцан ойлголцол, хамтын хүчин чармайлт амжилтын гол үндэс байдаг билээ. “Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах” Улсын Их Хурал (УИХ)-ын ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн 2019 оны сүүлээр гарсан УИХ-ын 92-р тогтоол нь хувьцаа эзэмшигчдийн харилцан ойлголцолд чухал алхам боллоо.

УИХ-аас уг тогтоолыг баталсантай холбогдуулан Рио Тинто болон Туркойз Хилл Ресурс компанийн зүгээс манай хамт олон, нийт түншлэгч талуудад хандаж өнгөрсөн оныг амжилттай үдсэнд баяр хүргэсэн нь оюутолгойчуудын урам зоригийг улам их бадраасныг тэмдэглэж байна.

Манай хамт олон бээр 2018 онд батлагдсан компанийн хөгжлийн 10 жилийн стратегийг цаашид хувьцаа эзэмшигчдийнхээ дэмжлэгт тулгуурлаж тууштай хэрэгжүүлэх болно. Чингэхийн тулд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийн зэрэгцээ ажилчдынхаа эрдэм мэдлэг, ур чадварыг ямагт сайжруулж, гүний уурхайн бүтээн байгуулалтаа үргэлжлүүлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг баталгаажуулж, Засгийн газар болоод Өмнөговь аймагтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх замаар улс орныхоо хөгжил дэвшилд дорвитой хувь нэмэр оруулахын төлөө зүтгэхийг зорино.

“Оюу толгой” компанийн нийт хамт олны нэрийн өмнөөс цаг үргэлж дэмжлэг туслалцаа үзүүлдэг нийт хувьцаа эзэмшигчдэдээ гүн талархах ялдамд цаашид ч урт хугацаанд хамтран ажиллахыг эрмэлзэж буйгаа илэрхийлье.

.....  
Элчин сайд Галсангийн Батсүх (Олон улсын харилцааны доктор)

# Гүйцэтгэх захирал, Гүний уурхайн төслийн захирлын МЭНДЧИЛГЭЭ



Армандо Торрес  
Гүйцэтгэх захирал



Марко Пирес  
Гүний уурхайн төслийн захирал

**2019 он “Оюу толгой” компанийн хувьд амжилт бүтээл, сорилт шалгуур дүүрэн жил болж өнгөрлөө. Бид Оюу толгой төдийгүй улс орны хөгжилд хувь нэмэр оруулах олон түүхэн амжилт гаргахын зэрэгцээ дэлхийд тэргүүлэх ил уурхайн үйл ажиллагаа, гүний уурхайн бүтээн байгуулалтаа аюул осолгүй үргэлжлүүлж, улам эрчимжүүлж чадлаа.**

Оюу толгойд ажиллаж буй хүн бүр аюулгүй ажиллагаа бол бидний амжилтын үндэс болохыг сайтар ухамсарлан ажилладаг. Иймдээ ч өнгөрсөн онд компанийн хэмжээнд тавьсан аюулгүй ажиллагааны зорилтоо давуулан биелүүлснээр 2018 оны компанийн дээд амжилтыг хадгалсан юм. Түүнчлэн ил уурхайн ашиглалт, үйл ажиллагааны хэсгийн аюулгүй ажиллагааны үзүүлэлтээр компанийн төдийгүй Оюу толгой төслийн менежер болох Рио Тинто группийн хэмжээнд дээд амжилт тогтоов.

Дэлхийн түвшний аюулгүй ажиллагааны соёлоо түншүүд, холбогдох байгууллагууд болон ард иргэдтэй хуваалцах нь бидний хувьд нийгмийн хариуцлагын эн тэргүүний ажлуудын нэг байдаг. 2019 онд бид Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо (МОШПА)-той хамтын ажиллагаагаа өргөжүүлж, салбарын хэмжээнд болон олон нийтийн дунд аюулгүй ажиллагааны соёл, туршлагаа түгээн дэлгэрүүллээ.

Байгаль орчны хариуцлагаараа түүчээлэгч байгууллагын хувьд бид говь нутагт ус хэчнээн чухал болохыг ойлгож, ихээхэн ач холбогдол өгдөг. Манай уурхай өнгөрсөн онд нэг тонн хүдэр боловсруулахдаа дэлхийн бусад ижил төстэй уурхайгаас даруй гурав дахин бага ус зарцуулж, нийт ашигласан усныхаа 87 орчим хувийг дахин ашигласан нь дэлхийд тэргүүлэх үзүүлэлт болсон.

Бидний хамгийн эрхэм, үнэт баялаг бол манай хамт олон билээ. Иймээс бид хамт олныхоо хөгжилд зориулан жил бүр олон зуун мянган хүн/цагийн сургалт зохион байгуулдаг. Үүний үр дүнд дотоодын ажиллах хүчний мэдлэг, чадавх жилээс жилд улам сайжирч, үйл ажиллагааны хэсэг болон гүний уурхайн бүтээн байгуулалтад ихээхэн хувь нэмэр оруулж байна. Манай нийт ажиллах хүчний 93 хувийг монгол ажилтнууд бүрдүүлдэг бөгөөд тэдгээрийн талаас илүү хувь нь гүний уурхайг бүтээн байгуулах төсөл дээр ажиллаж байна. Бид “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэх” алсын хараагаа хэрэгжүүлэн боловсролын төсөл, хөтөлбөрүүдээрээ дамжуулан Монголын ирээдүй хойч үеийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулсаар байна. 2019 он хүртэл манай боловсролын хөтөлбөр, тэтгэлэгт нийт 2,600 оюутан, залуус хамрагджээ.

2019 онд “Оюу толгой” компани дотоодын 564 компанитай хамтран ажиллаж, дотоодын худалдан авалтад 431 сая ам.доллар зарцуулсан. Энэ нь улсын болон орон нутгийн эдийн засгийг хөгжүүлж, төрөлжүүлэхэд бидний зүгээс оруулж буй нэгээхэн хувь нэмэр юм. Монгол Улсын хамгийн том татвар төлөгчдийн нэгийн хувьд бид 2010 оноос буюу төсөл эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл татвар, хураамж болон бусад төлбөрт нийтдээ 2.6 тэрбум ам.доллар төлөөд байна. “Оюу толгой” компани 2010-2019 онд ажилчдын цалин хөлс, дотоодын ханган нийлүүлэгчдийн төлбөр, улсад төлдөг татвар болон бусад төлбөрт нийтдээ 10.3 тэрбум ам.долларыг улсын хэмжээнд зарцуулаад байгааг мэдээллэхэд таатай байна.

Бид орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, суурь дэд бүтэц байгуулах, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээг сайжруулахад чухалчлан анхаарч, дэмжлэг үзүүлсээр байна. 2019 онд компанийн санхүүжилтээр "Говийн Оюу" хөгжлийг дэмжих сангаар дамжуулан Өмнөговь аймагт анхны магадлан итгэмжлэгдсэн, орчин үеийн лаборатори бүхий мах боловсруулах анхны үйлдвэр, Мандал-Овоо суманд 10 ортой эмнэлэг, Манлай суманд 100 хүүхдийн цэцэрлэг болон Баян-Овоо суманд уурын зуухны барилгыг тус тус ашиглалтад оруулсан билээ. "Говийн Оюу" хөгжлийг дэмжих сан нь орон нутагтай хийсэн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг ханган, удирдан зохион байгуулах эрх бүхий бие даасан хуулийн этгээд юм.

Хэдийгээр ил уурхайн хүдрийн агуулга буурч, АНУ-БНХАУ хоорондын худалдааны маргаанаас үүдэн зэсийн үнэ унасан зэрэг сорилттой нүүр тулсан ч бид мэргэжлийн хамт олныхоо өндөр ур чадварт түшиглэн зэс, алтны үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн. Ил уурхай, баяжуулах үйлдвэрийнхээ үр ашгийг нэмэгдүүлж, салбартаа тэргүүлэгчийн байр сууриа мөн хадгалж чадлаа. "Бизнесийг шинэчлэх хөтөлбөр"-ийн хүрээнд асуудалд эзний ёсоор хандах соёлыг байгууллагын хэмжээнд төлөвшүүлэх замаар бид бизнесээ илүү үр дүнтэй явуулахын төлөө чармайн ажилласаар байна.

Зах зээлд мэдээлэгдсэний дагуу бид гүний уурхайн зураг төслийг шинэчлэн тодотгох ажлыг 2020 оны эхний хагаст, үүнтэй холбоотой гүний уурхайн тооцоог 2020 оны хоёрдугаар хагаст бэлэн болгохоор ажиллаж байна. Хэдийгээр гүний уурхайн бүтээн байгуулалтын явцад бид ихээхэн хүндрэл, сорилтуудтай тулгарч байгаа ч ажил тууштай урагшилж, "Оюу толгой" уурхай дэлхийн томоохон зэсийн уурхай болоход улам ойртсоор байна.

2019 оны 8 дугаар сард гүний уурхайн үйл ажиллагааны гол цөм болох захиргаа, үйлчилгээний "Чандмань" төвийг ашиглалтад оруулсан билээ. Тус төв нь "Оюу толгой" уурхайн цогцолборын газрын гадарга дээрх хамгийн том байгууламжийн нэг юм. Үүнээс удалгүй гүний уурхайн үйл ажиллагааны амин сүнс болсон "Үйлдвэрлэлийн ам"-ыг амжилттай барьж дуусгасан явдлыг баяртайгаар тэмдэглэсэн. Дэд бүтцийн эдгээр байгууламжийг барьж дуусгаснаас гадна бид гүний уурхайн хөндлөн нэвтрэлтийн ажлын бүтээмжийг 40 хувиар ахиулж чадсан билээ.

2020 он бидэнд олон шинэ боломжийг нээхийн сацуу цөөнгүй сорилт, шалгуур бүхий жил байх болно. Хэдий тийм ч Оюу толгойн бүтээлч хамт олон бид найдвартай түншүүд болон хувьцаа эзэмшигчдийнхээ хамтаар дахин нэг жилийг амжилт бүтээлээр дүүрэн үднэ гэдэгт итгэлтэй байна.

Аливаа сорилт болон амжилт бүхэнд бидэнтэй хамт байж, байнга дэмжлэг үзүүлж ирсэн Та бүхэндээ гүн талархал илэрхийлье. Та бүхний дэмжлэггүйгээр бид өнөөдрийн амжилтад хүрэх боломжгүй байсан билээ.

Монголын ард түмэн, төслийн оролцогч талуудын хамт дэлхийд тэргүүлэх зэсийн уурхайг цогцлоож Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах туйлын бөгөөд эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд бид тууштай хичээн ажиллах болно.

.....  
Армандо Торрес  
Гүйцэтгэх захирал

.....  
Марко Пирес  
Гүний уурхайн төслийн захирал



# Компанийн тухай

**Оюу толгой нь Монгол Улсын Өмнөговь аймагт оршдог дэлхийн хэмжээний уурхай бөгөөд ээсийн агуулгаараа дэлхийд тэргүүлдэг ордуудын нэг.**

**“Оюу толгой” ХХК нь “Туркойз Хилл Ресурс” ХК (66 хувь) болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК (34 хувь)-ийн хувь нийлүүлсэн компани юм. Хувь нийлүүлэгч “Эрдэнэс Оюу толгой” ХХК нь Монгол Улсын төрийн өмчит компани. “Туркойз Хилл Ресурс” ХК -ийн дийлэнх буюу 51 хувийг “Рио Тинто” групп эзэмшдэг. “Рио Тинто” 2010 оноос хойш Оюу толгойн стратеги болон үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлж байна.**

**“Оюу толгой” уурхайн цогцолбор Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 км, Монгол-Хятадын хилээс хойш 80 орчим километр оршдог. Олон арван жилийн хайгуулын үр дүнд Оюу толгойн ордыг 2001 онд нээн илрүүлсэн түүхтэй.**

Уул уурхайн бизнесийн бүхий л чиглэлээр мэргэшсэн гүйцэтгэх удирдлагын баг “Оюу толгой” компанийг удирдан, стратегийн бодлогыг хэрэгжүүлдэг. “Оюу толгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигч талуудын төлөөллөөс бүрддэг бөгөөд компанийн стратегийн чиглэлийн дагуу шийдвэр гаргах, хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг.

2019 оны эцсийн байдлаар Оюу толгойн нийт ажиллах хүчний 93 хувь нь монгол ажилчид байсан бөгөөд тэдний 23 хувийг Өмнөговь аймгийн ажиллах хүчин бүрдүүлжээ.

“Бидний ажлын арга барил” хэмээх “Оюу толгой” компанийн бизнесийн ёс зүйн дүрмийг бид бизнесийн аливаа шийдвэр гаргахдаа мөн ажилтан бүр ажлаа гүйцэтгэхдээ мөрдлөг болгон ажилладаг. Энэхүү ёс зүйн дүрэмд байгаль орчны хамгаалал, тогтвортой хөгжил, авилгаас ангид байх, ажилчдын ёс зүй, эрх үүрэг тусгагдсан болно.

“Оюу толгой” компани үйлдвэрлэсэн зэс, алтны агуулгатай баяжмалаа спот болон урт хугацаатай хэлцэл байгуулан олон улсын зах зээлд борлуулдаг.

Уурхайн ашиглалтын хувьд ил уурхайгаас хүдэр олборлож, хоногт 100,000 тонн хүдэр баяжуулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр, дагалдах байгууламж, дэд бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Гүний уурхайн бүтээн байгуулалтын үйл явц 60 гаруй хувийн гүйцэтгэлтэйгээр амжилттай урагшилж байна. Гүний уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед “Оюу толгой” компани бага өртгөөр үйлдвэрлэл явуулдаг дэлхийд өрсөлдөхүйц томоохон ээсийн уурхайн нэг болох юм.

2019 онд “Оюу толгой” компани 10 жилийн хөгжлийн стратегийнхээ дагуу аюулгүй ажиллагаа, хамт олон, түншлэл, мөнгөн хөрөнгө, өсөлт гэсэн таван үндсэн чиглэлд төвлөрч ажиллалаа. Бид зах зээлийн үл тасрах сорилтуудыг даван туулахын сацуу дэлхийн хэмжээний уурхайн төслийг хэрэгжүүлэн, зах зээлийн тэргүүлэгч байр сууриа хадгалсаар байна.

# Алсын хараа, манай ирээдүй

Алсын хараа > Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ					
Эрхэм зорилго > Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна					
Үнэт зүйлс >	Аюулгүй ажиллагаа	Хамтын зүтгэл	Хүндэтгэл	Ёс зүй	Төгөлдөршил
Тэргүүлэх чиглэл					
Үндсэн зорилт	<p>Аюулгүй ажиллагаагаа улам бататгаж, салбартаа тэргүүлнэ</p> <p>Дэлхийн жишигт нийцсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаагаа хадгална</p>	<p>Чадварлаг, эвсэг хамт олныг бүрдүүлнэ</p> <p>Хөдөлмөр эрхлэх шударга, нээлттэй орчныг бэхжүүлнэ</p> <p>Авьяас, ур чадварыг үргэлжлүүлэн хөгжүүлнэ</p>	<p>Бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж, үр ашгаа нэмэгдүүлнэ</p> <p>Шинийг эрэлхийлсэн, эзний сэтгэлгээтэй, бүтээлч хамт олныг төлөвшүүлнэ</p>	<p>Хамтран ажиллагч талуудтай үр ашигтай, эерэг харилцаагаа бэхжүүлнэ</p> <p>Өмнөговийн бизнес эрхлэлт, орон нутгийн бие даасан, тогтвортой хөгжлийг дэмжинэ</p> <p>Өрсөлдөх чадвартай, үндэсний ханган нийлүүлэлтийн тогтвортой сүлжээг дэмжинэ</p>	<p>Гүний уурхайн бүтээн байгуулалтыг хугацаанд нь дуусган, бүрэн хүчин чадалд нь хүргэснээр Оюу толгойн ирээдүйг баталгаажуулна</p> <p>Түншийн тогтвортой харилцааг эрхэмлэн бэхжүүлнэ</p> <p>Бүтээгдэхүүнийг зах зээлд осол аюулгүй, түргэн шуурхай хүргэх чадавх бүхий ханган нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлнэ</p>

2019 оны туршид “Оюу толгой” ХХК “Алсын хараа - Манай ирээдүй” буюу компанийнхаа алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, тэргүүлэх чиглэлүүдийг удирдамж болгон ажиллалаа.

2015 оноос хойш нийт компанийн хэмжээнд мөрдөж буй энэхүү “Алсын хараа - Манай ирээдүй” нь биднийг аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахыг гол зорилгоо болгон ажиллахад маань үндсэн чиг шугам болж байдаг.

Бид хүндэтгэл, ёс зүй, хамтын зүтгэл, хариуцлага болон төгөлдөршил гэсэн таван үнэт зүйлсээ өдөр тутам тууштай эрхэмлэн ажилладаг. Эдгээр үнэт зүйлс маань бидний зан харилцаа, хандлага мөн бизнесийн хувьд биднийг хэн болохыг, юуны төлөө зорьж байгааг тодорхойлдог.

“Алсын хараа - Манай ирээдүй” нь манай бизнесийн тэргүүлэх таван чиглэлийг мөн тодорхойлсон байдаг.

## Тэргүүлэх чиглэл



**Аюулгүй ажиллагаа**




**Хамт олон**



**Мөнгөн хөрөнгө**



**Түншлэл**



**Өсөлт**









# Санхүүгийн гүйцэтгэл

## Үнэ

Зэсийн үнэ 2019 онд дунджаар 6,004 ам.доллар/тонн байлаа. Оны эхний хагаст БНХАУ эдийн засгаа эрчимжүүлэх арга хэмжээ авсан, АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын ханшаа өсгөхөөс түдгэлзсэн, мөн АНУ-БНХАУ-ын худалдааны дайн төдийлөн санаа зовоох хэмжээнд хүрээгүй байсан зэргээс шалтгаалан зэсийн үнэ өндөр байв (6,165 ам.доллар/тонн). Харин оны сүүлийн хагаст худалдааны сөргөлдөөн нэмэгдэж, Европ тив болон АНУ, БНХАУ-д макро эдийн засгийн үзүүлэлтүүд муудсанаас үүдэн зэсийн үнэ унаж, дунджаар 5,842 ам.доллар/тонн болсон.

Харин алтны үнийн өөрчлөлт эсрэг чиглэлтэй байлаа. Тухайлбал, алтны үнэ 2019 онд дунджаар 1,320 ам.доллар/унц, хамгийн ихдээ 9 дүгээр сард 1,557 ам.доллар/унц болж өссөн нь зах зээлийн оролцогчид худалдааны дайны эрсдэлээс зайлсхийсэн, төв банкууд ам.доллараас татгалзаж, алт худалдан авах болсон, мөн биржид арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангуудын алтны хадгаламж ихээхэн нэмэгдсэнтэй холбоотой юм.

## Орлого

Үйлдвэрлэсэн зэсийн хэмжээ буурсан, хүдэр дэх зэсийн агуулга бага байснаас борлуулалтын орлого 2018 оныхоос буурсан. Тэгэхдээ борлуулсан алтны хэмжээ нэмэгдэж, алтны үнэ өндөр байсан нь зэсийн үнэ унаж, борлуулалтын хэмжээ буурснаас үүдсэн нөлөөллийг тодорхой хэмжээгээр нөхөж чадлаа.

2019 онд “Оюу толгой” компани 150 мянган тонн зэс (2018 онд 157 мянган тонн), 274 мянган унц алт (2018 онд 248 мянган унц), 896 мянган унц мөнгө (2018 онд 873 мянган унц) тус тус агуулсан 725 мянган тонн баяжмал (2018 онд 746 мянган тонн) борлуулж, 1,166 сая ам.долларын (2018 онд 1,180 сая ам.доллар) -ын орлого олсон.

## Үйлдвэрлэл

2018 онд уулын цул тээвэрлэлт 91 сая тонн байсан бол 2019 онд 101 сая тонн болж нэмэгдсэн. Энэ нь ил уурхайн олборлолтын 6В үе шат руу шилжиж, ачаа эргэлтийн хугацаа богиноссонтой холбоотой. Боловсруулсан хүдрийн хэмжээ 6 хувиар нэмэгдэж 41.2 сая тонн болсон нь тээрмийн бэлэн байдал нэмэгдсэн, мөн зөөлөн хүдэр боловсруулах болсноор тээрмийн гарц нэмэгдсэнтэй холбоотой.

Сая ам.доллар	2019	2018	2017	2016	2015
Борлуулалтын орлого	1,166	1,180	940	1,203	1,635
Үндсэн үйл ажиллагааны, Татвар, хүү, элэгдлийн өмнөх ашиг*	350	346	230	390	553
Үндсэн үйл ажиллагааны, Татвар, хүү, элэгдлийн өмнөх ашгийн хувь (%)**	30%	29%	24%	32%	34%
Урсгал капиталын зардал	134	91	82	101	125
Гүний уурхайн бүтээн байгуулалтын капитал зардал	1,185	1,242	852	230	-
Улсад төлсөн татвар, шимтгэл, бусад төлбөр	209**	200	180	189	256

## Урсгал капиталын зардал

Урсгал капиталын зардал 2018 оныхоос 43 сая ам.доллараар өссөн нь 2019 онд ил уурхайн олборлолт 6В үе шат руу шилжсэнээс хоосон чулуулгийн тээвэрлэлт нэмэгдэж, хойшлуулсан хөрс хуулалтын капитал зардал 29 сая ам.доллараар, мөн хаягдал хадгалах байгууламжийн барилга угсралтын зардал 5 сая ам.доллараар тус тус өссөнөөс голлон шалтгааллаа.

\*Орлогын татвар, Хүүгийн зардал, Элэгдэл, Хорогдлыг тооцохын өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг нь орлогын тайланд тусгагдсан орлогын татвар, санхүүгийн цэвэр зардал, элэгдэл, хорогдлын зардлыг тооцохын өмнөх ашгийг харуулах ба энэ дүн нь үнэ цэнийн бууралтын ямар нэгэн нөлөөг агуулаагүй болно.

\*\* НӨАТ ороогүй дүн. “Оюу толгой” ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.





### **Гүний уурхайн бүтээн байгуулалтын капитал зардал**

2019 онд гүний уурхайн бүтээн байгуулалтын капитал зардал 1,185 сая ам.доллар буюу 2018 оныхоос 57 сая ам.доллараар бага байгаа нь газрын гадарга дээрх дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж дууссантай холбоотой.

2016 оны нэгдүгээр сараас хойш өнөөдрийг хүртэл өнөөдрийг хүртэл гүний уурхайн төсөлтэй холбоотой гарсан нийт зардал 3.5 тэрбум ам.долларт хүрээд байна. Төслийн хүрээнд байгуулсан нийт гэрээ хэлцлийн дүн 4.3 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнээс 2.9 тэрбумын гэрээ хэлцлийг дотоодын 132 ханган нийлүүлэгчтэй байгуулснаар 2016 онд анх тавьсан 1.4 тэрбум ам.долларын зорилтыг давж биелүүллээ. Гүний уурхайн бүтээн байгуулалтад үндэсний компаниудтай үргэлжлүүлэн хамтран ажиллаж байгаа ба 2019 онд дотоодын ажиллах хүчний оролцоо 77 хувьд хүрсэн нь тооцролж байснаас хавьгүй өндөр байна.

### **Татвар, хураамж болон бусад төлбөр**

2019 онд Засгийн газарт татвар, шимтгэл болон бусад төлбөрт 209 сая ам.доллар\* төлсөн нь 2018 оныхоос 9 сая ам.доллараар давуу байна. Энэ нь жилийн төлбөр төлөлтийн хуваариас хамааран ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 6 сая ам.доллараар өссөн (2019 онд 71 сая ам.доллар, 2018 онд 65 сая ам.доллар), ажиллах хүчний тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт 4 сая ам.доллараар (2019 онд 25 сая ам.доллар, 2018 онд 21 сая ам.доллар) тус тус нэмэгдсэнтэй холбоотой.

Гүний уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, төслийн санхүүжилтийн зээлийн хүүг төлөх зорилгоор 2019 онд 1,375 сая ам.долларын (2018 онд 1,270 сая ам.доллар) санхүүжилт татсан. Санхүүжилтийн 645 сая ам.долларыг (2018 онд 515 сая ам.доллар) энгийн хувьцаа, 730 сая ам.долларыг (2018 онд 755 сая ам.доллар) хувьцаа эзэмшигчээс олгосон зээл хэлбэрээр татсан. 2019 онд гаднаас авсан санхүүжилт төлөвлөсөн хэмжээнээс бага байгаа нь үйл ажиллагаанаас орсон орлого нь тухайн үйл ажиллагааны урсгал капиталын зардлаас давсантай холбоотой. Оны эцэст нийт зээлийн хэмжээ 10.6 тэрбум ам.доллар байв.

\* НӨАТ ороогүй дүн. "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

# Зохистой зарцуулалтын арга ХЭМЖЭЭ

Тус компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Бизнес шинэчлэлтийн хөтөлбөр” нь байгууллагадаа эзний ёсоор хандах соёлыг төлөвшүүлэх замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлох, түүнийг нэмэгдүүлэх, мөн компанийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулахад чиглэдэг. Уг хөтөлбөр нь орлого нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардал бууруулах, ажлын цэвэр капитал болон капиталын урсгал зардал хэмнэх зэрэг бизнесийн үнэ цэнийн тулгуур хүчин зүйлсэд төвлөрч хэрэгждэг юм.

“Бизнесийн нийт боломжийг бүрэн дайчлах бүтэц” бүрдүүлэх явц нь тус компанийн үйл ажиллагааг 2-3 жилийн дотор дорвитой сайжруулах арга замыг тодорхойлох хэрэгсэл юм. Эдгээр арга хэмжээ болон “Уурхайн төлөвлөлт”-ийн алба зэрэг бусад нэгжийн үлэмж их хүчин чармайлтын дүнд 2019 онд нийт 218 сая ам.долларын хэмнэлт бүрдүүлсэн нь анх төлөвлөгдсөн 201 сая ам. доллараас давж биелсэн байна.

2019 оны зарим гол амжилт:

- » “Бизнес шинэчлэлтийн хөтөлбөр” нь компанийн нийт үйл ажиллагааны салшгүй хэсэг болсон.
- » Компанидаа эзний ёсоор хандах соёлыг төлөвшүүлэх, асуудал шийдэх ур чадвар эзэмшүүлэх үйл явцыг үргэлжлүүлж байна.
- » Бизнесийн нийт боломжийг илрүүлж тодорхойлох, бүрэн дайчлах, хэрэгжилтийг нарийвчлан төлөвлөх зөвлөгөөнийг гурав дахь жилдээ зохион байгуулсан.
- » Бүтээмж сайжруулах багцад нийт 195 хүний санаачилж дэвшүүлсэн 684 төсөл хэрэгжих шатандаа явж байна.
- » “Кайзен” болон “Асуудлыг түргэн шийдэх арга зам” семинар 22 удаа зохион байгуулагдсан бөгөөд эдгээрт нийт 300 гаруй хүн оролцсон.
- » Хэлтэс тус бүрийн өдөр ба долоон хоног тутмын зардлыг хянах явцад түлхүү анхаарсны дүнд компанийн зардал мэдэгдэхүйц буурч байна.

## “Бизнес шинэчлэлтийн хөтөлбөр”-ийн үр дүн

(сая ам.доллар)




# Худалдан авалт, хангамжийн сүлжээ

“Оюу толгой” компани найдвартай бүтээгдэхүүн, үйлчилгээний ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгох замаар үйл ажиллагаандаа аль болох илүү үр өгөөж авчрах, улмаар улсын хэмжээнд болон Өмнөговь аймагт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгож, дотоодын ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхээр зорин ажиллаж байна.

2019 онд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдэд зарцуулсан худалдан авалтын дүн тасралтгүй нэмэгдэж үйл ажиллагааны нийт худалдан авалтын 87 хувьд хүрсэн байна. Нийт 838 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласан бөгөөд тэдний 564 нь үндэсний компани юм. 2010-2019 оны хооронд үндэсний худалдан авалтад нийт 3.1 тэрбум ам.доллар зарцуулаад байна. Өмнөговь аймгаас худалдан авалт жил бүр нэмэгдэж, 2010 онд 0.5 сая ам.доллар байсан бол түүнээс хойш тууштай өсч, 2019 онд 141 сая ам.доллар болжээ.


## Үндэсний худалдан авалт (2010-2019)

(сая ам.доллар, жилээр)



## Өмнөговь аймгийн худалдан авалт (2010-2019)

(сая ам.доллар)



### “Монголд үйлдвэрлэв” хөтөлбөр

Энэхүү хөтөлбөр нь 2019 онд орон нутагт үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүн болон дотоодод үйлдвэрлэгдсэн ган төмөрлөг болон төрөл бүрийн цахилгаан бүтээгдэхүүнээр хүрээгээ тэллээ. Уг хөтөлбөрийн хүрээнд жилдээ 9 сая ам.долларын өртөг бүхий 10 шинэ “Монголд үйлдвэрлэв” гэрээ хийснээр 200 гаруй ажлын байрыг бий болгов.

Олон улсын чанарын шаардлага хангасан хамгийн анхны Монголд үйлдвэрлэсэн хөдөлмөр хамгааллын гутал манай уурхайчдын хэрэглээ болоод байна. Өмнөговь аймагт нийт долоон шинэ үйлдвэр нээж, худалдан авалтын гэрээ байгуулснаас гадна Манлай суманд хоёр үйлдвэр ашиглалтад оров.



### Ханган нийлүүлэгчдийг чадавхжуулах хөтөлбөр

Энэ хөтөлбөр нь тогтвортой, зардал багатай ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход чиглэж байна. 2019 оны хувьд тус хөтөлбөр нь хөгжлийн дараагийн үе рүү шилжиж, үйлдвэрлэлийн менежмент, ашигтай төсөл бичих чиглэлээр ахисан түвшний сургалтууд, танхимын болон ганцаарчилсан зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн хүнс, хөдөө аж ахуй, агро бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоршоод, бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж, анхан шатны сургалтад хамрууллаа. Нийт 2,145 оролцогч





хамрагдсанаас оролцогч компаниудын ажил эрхлэлтийн түвшин дунджаар 50 хувь, борлуулалтын орлого 34 хувиар тус тус нэмэгдсэн үр дүнтэй байна\*.

\* Бизнесийн инноваци, хөгжлийн төвийн дотоод үнэлгээ  
 “Оюу толгой” компани нь дотоодын арилжааны банкуудтай хамтран ханган нийлүүлэгчдэд бага хүүтэй, тааламжтай нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүнийг хүргэх зорилгоор ханган нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн хөтөлбөрийг гурван жилийн өмнөөс хэрэгжүүлж эхэлсэн. 2019 онд нийт 166 ханган нийлүүлэгч 216 сая ам долларын зээлийн санхүүжилтийг түншлэгч банкуудаас авсан.





# Аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд болон байгаль орчин

## Аюулгүй ажиллагаа

Аюулгүй ажиллагааны үндсэн тулгуур болсон дараах хөтөлбөрүүдийг тасралтгүй хэрэгжүүлсээр байна. Үүнд:

- » Амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх – Ноцтой эрсдэлийн удирдлага (НЭУ)
- » Гамшгаас урьдчилан сэргийлэх - Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны менежмент (ҮААМ)
- » Бэртэл гэмтлийг бууруулах

2019 оны эцсийн байдлаар 200,000 хүн/цагт ногдох бүх гэмтэл, бэртлийн давтамж (БГБД) 0.16 хүртэл буурч, уг үзүүлэлтээр Рио Тинто группийн хэмжээнд тэргүүлэх уурхайн нэг боллоо. Үйл ажиллагааны хэсгийн 200,000 хүн/цагт ногдох БГБД нь 0.09 үзүүлэлттэй байсан нь компанийн хувьд дээд амжилт болсон юм.

### 2019 оны зарим амжилт:

- » Гуравдагч талын магадлан итгэмжлэлээр олон улсын ISO 14001, OHSAS 18001 ЭМААБО-ны Удирдлагын системийн стандартыг бүрэн хангасан.
- » Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо (МОШПА)-той хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг хөгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж ажилласан.
- » Удирдах ажилтнууд ажлын байрны эрсдэлийг арилгах 280,000 орчим магадлагаа хийсэн.

Рио Тинтогийн Аюулгүй ажиллагааны хөгжлийн загвар (ААХЗ)-ыг аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд нэвтрүүлж эхэлсэн. Ингэснээр Оюу толгойн аюулгүй ажиллагааны үнэлгээг группийн хэмжээнд харьцуулан, харилцан суралцах боломж бүрдүүлж, аюулгүй ажиллагааны стратегийн гурван гол зарчмыг хангасан.

Ноцтой эрсдэлийн удирдлага нь “Аюулгүй ажиллагааны коучинг хөтөлбөр”-өөр дамжуулан тооноос чанарт түлхүү анхаарах болсон. Коучинг хөтөлбөр нь аюулгүй ажиллагааны хандлага, үр дүнг сайжруулж, улмаар удирдах ажилтан ба баг хоорондын харилцааг идэвхжүүлэн, ААХЗ-ын дараах дөрвөн үндсэн хэрэгслүүд дээр мэргэших боломжоор хангаж байна. Үүнд:

- » Ноцтой эрсдэлийн удирдлагын коучинг
- » Аюулгүй ажиллагааны сургалт
- » Ажил эхлэхийн өмнөх хурал, зөвлөгөөн
- » Аюулыг таньж, илрүүлэх


**2019 оны эцсийн байдлаар 200,000 хүн/цагт ногдох бүх гэмтэл, бэртлийн давтамж (БГБД) 0.16 хүртэл буурч, уг үзүүлэлтээр Рио Тинто группийн хэмжээнд тэргүүлэх уурхайн нэг боллоо.**

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь тайлангийн хугацаанд голчлон анхаарсан нэг чиглэл байсан болно. Үүний хүрээнд үйлдвэрлэлийн орчин дахь аюулыг таньж, илрүүлэх ажлуудыг гүйцэтгэж, ахлах удирдлага болон хяналтыг хэрэгжүүлэх багаас 800 гаруй магадлагааг хийж, үйл ажиллагааны ноцтой эрсдэлийн удирдлага үр дүнтэй явагдаж байгаа эсэхэд хяналт хийлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 21 аймгийн салбарыг төлөөлж ирсэн 71 улсын байцаагч, төрийн өмчит аж ахуй нэгж, хувийн хэвшлийн 180 төлөөлөгчийг Оюу толгойн уурхайн цогцолборт хүлээн авч, Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны (ЭМААБО) удирдлагын тэргүүн туршлагаасаа хуваалцаж, ЭМААБО удирдлагын стандартын хэрэгжилтийг ажлын талбар дээр танилцууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог төгөлдөржүүлэх “Нэн түрүүнд ХАБ-2019” бага хурлыг “Аюулгүй байдалд манлайлах нь” уриан дор “Оюу толгой” ХХК, МОШПА, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран зохион байгуулсан.

## Бүх гэмтэл бэртлийн давтамж (БГБД) (Үйл ажиллагаа болон гүний уурхай)



## Эрүүл мэнд

Ханбогд сумын эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, улмаар сумын иргэдийн эрүүл мэндийг дэмжихийн зэрэгцээ компанийн ажилчдын эрүүл мэндийн үзлэгийг орон нутагт явуулахад анхаарч ажилласан.

Ажилчдын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дараах ажлыг хийлээ. Үүнд:

- » Эрүүл мэндийн уриалгат арга хэмжээг ажилчдын дунд өрнүүлсэн.
- » Алжаал ядаргааны судалгаа явуулж, ажилчдын эрүүл мэндийн үнэлгээг хийсэн.
- » Мөн тэргүүн эгнээний ажилчдын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад хийсэн ажил:
  - » Амьсгалын замыг хамгаалах хэрэгслүүдийг шинэчилсэн.
  - » 2,000 ажилчдад чихний бөглөө, амьсгалын замыг хамгаалах хэрэгслийг тааруулах ажлыг хийсэн.
  - » Ажилчдын шингэний дутагдал, нөхөлтийн судалгааг зуны улиралд явуулсан.
  - » Бүх гар багажны дуу чимээг хэмжиж, судалгаа явуулав.

## Байгаль орчин

Оюу толгойн уурхайн тогтвортой үйл ажиллагааг орон нутагтай хамтран хэд хэдэн хараат бус аудитаар хянуулж, баталгаажуулсан. Үүнд:

- » Аймгийн байгаль орчин хамгаалах газрын шалгалт
- » Зээлдүүлэгчдийн хараат бус байгаль орчин, нийгмийн нөлөөллийн аудит
- » ISO14001 магадлан итгэмжлэлийн аудит
- » Орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй талбайд очиж, бодит байдалтай танилцан, хамтарсан хяналт хийсэн.

### Ус

Гүний ус нь говь нутгийн чухал баялаг учраас түүнийг дээд зэргээр ариг гамтай ашиглахын тулд хамгийн бага ус хэрэглэдэг шилдэг технологи ашигладаг. 2019 онд нэг тонн хүдэр боловсруулахдаа 0.4м/кубээс бага ус ашиглаж, ус дахин ашиглалтын түвшинг нэмэгдүүлж, дунджаар 87 хувьд хүргэлээ.

### Биологийн олон янз байдал

Биологийн үндсэн олон янз байдлын мониторингийн хөтөлбөрөөр бүс нутгийн биологийн олон янз байдлын гол үзүүлэлтүүдийг хэмжлээ. Хөтөлбөрийн хүрээнд хулан, хар сүүлт зээрийн тооллого явуулж, 2015 оны тооллогоос хойш тоо толгой 30 ба 70 хувиар тус тус нэмэгдсэнийг тогтоосон.

Биологийн олон янз байдлыг дэмжих чиглэлээр хийгдсэн бусад ажил:

- » Бүсийн ургамлын чуулганыг орон нутгийн засаг захиргаа, Байгаль орчин хамгаалах газрын хамт зохион байгуулсан.
- » Орон нутгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор "Тогтвортой ноолуур" төсөл, хулгайн ангийн эсрэг санаачилгын хүрээнд орон нутгийн зөвлөгөөнийг зохион байгуулсан.







### **Нөхөн сэргээлт**

Оюу толгой - Ханбогдын засмал замтай холбоотой 109 га газрын техникийн нөхөн сэргэлтийг дуусгасан. Хуучин нисэх зурваст (43 га газар) Оюу толгойн мод үржүүлгийн төвөөс нутгийн уугуул долоон төрлийн ургамлыг суулгаж, биологийн нөхөн сэргээлт хийлээ.

### **Хаягдал**

Оюу толгойн эрдсийн бус хаягдлын дахин ашиглалтыг 54 хувьд хүргэсэн нь 2018 оны 46 хувиас эрс өссөн үзүүлэлт боллоо.



## Аюулгүй байдал ба гэнэтийн аюулд хариу үзүүлэх ТОГТОЛЦОО

### Аюулгүй байдал

Хүний эрх, аюулгүй байдлын сайн дурын зарчмууд нь аюулгүй байдлын бүхий л үйл ажиллагааны суурь болдог ба гэрээт харуул хамгаалалтын ажилчдын сургалтад тусгалаа олсон байдаг. Ханбогд сумын цагдаагийн тасагтай хамтран боловсруулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэн зөрчлийн мэдээ тайлан, зөрчлийн байдалд хийх дүн шинжилгээг сайжруулснаар 2018 оныхтой харьцуулахад уурхайн цогцолборт гарсан зөрчлийн тоо буурсан.

### Үйл ажиллагааны хэсгийн Гэнэтийн ослын үед хариу үзүүлэх баг

Гадаргын гэнэтийн ослын үед хариу үзүүлэх баг нь уурхайн цогцолбор дээр 23 дуудлага, орон нутагт таван дуудлагад тусламж үзүүллээ. Гүний уурхайн бүтээн байгуулалт болон барилга угсралтад дэмжлэг үзүүлэх зорилгоор галын хоёр машин шинээр авч, гэнэтийн ослын үед хариу үзүүлэх хүчин чадлаа нэмэгдүүллээ.

### Уурхайн аврах сургалт

Гүний уурхайн аврах баг 24,700 цагийн сургалтыг 170 сайн дурын аврагчдад хийлээ. Үүнд уурхайн аврах ажиллагааны үндсэн ур чадварын сургалт, уурхайн аврах багийн давтан сургалт, анхны тусламжийн багийн галын аюулгүй байдлын сургалт, төрийн албан хаагчдад зориулсан ОБЕГ-тай хамтарсан сургалтууд тус тус оров.

### Онцгой байдлын ерөнхий газар - Уурхайн аврах тасаг

Оюу толгойн гүний уурхайн аврах баг нь Онцгой байдлын ерөнхий газрын уурхайн аврах тасагтай нягт холбоотой ажиллаж, дөрвөн удаагийн найман өдрийн сургалтаар уурхайн аврах ажиллагааны дүрэм журамтай танилцаж, гүний уурхайд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах дадлага сургуулилт хийлээ.









# ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХҮЙЦ ҮЙЛДВЭРЛЭЛ

2019 онд ил уурхайн үйл ажиллагааны хувьд бага агуулгатай хүдэр олборлож эхэлсэн, мөн АНУ болон БНХАУ хоорондын худалдааны зөрчлөөс хамааран зэсийн үнэ унасан зэрэг сорилттой тулгарсан. Гэхдээ мэргэжлийн, чадварлаг хамт оныхоо хичээл зүтгэлийн үр дүнд үйлдвэрлэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн. Ил уурхай ба баяжуулах үйлдвэрийн бүтээмжийг сайжруулснаар салбартаа тэргүүлэгч байр сууриа хадгалж чадсан болно.

Ил уурхайн олборлолт нь агуулга багатай хэсэг рүү шилжсэнээр олборлосон зэсийн хэмжээ 2018 оныхтой харьцуулахад урьдчилан тооцоолсны дагуу 8 хувиар буурсан. Мөн зэсийн агуулга 11 хувиар бага байсан ч бүтээмжийг нэмэгдүүлснээр гарцын зөрүүг тодорхой хэмжээгээр нөхсөн юм.

## Ил уурхай


Ил уурхайн өргөтгөлийн ажил 2019 оны турш амжилттай үргэлжилсэн. Өндөр агуулгатай хүдэр олборлох 4А ба 6А үе шатыг аюулгүй гүйцэтгэж дуусгасан ба төлөвлөгөөний дагуу 4Б болон 6Б үе шат руу шилжээд байна. Ил уурхайн нийт материалын тээвэрлэлт 101.3 сая тонн хүртэл өссөн. Өөрөө буулгагч автомашины ашигт ажиллагааны түвшинг 77 хувьд хүргэснээр салбартаа тэргүүлж, дундаж ачилтыг тасралтгүй нэмэгдүүлснээр оны эцэст нэрлэсэн даацыг 111 хувь хүртэл ахиулж, уулын ажлын хэмжээг нэмэгдүүлж чадлаа.

## Баяжуулах үйлдвэр

Өнгөрсөн онд 40.8 сая тонн хүдэр боловсруулсан нь үйлдвэрлэл эхэлснээс хойш хоёр дахь хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Хүдрийг хатуулгаар нь дундажлах, нунтаглалтын бүхэллэгийг оновчтой болгох, тээрмийн хуягны эдэлгээний хугацааг уртасгах зэрэг санаачилгыг хэрэгжүүлснээр бүтээмж нэмэгдлээ. Мөн үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад чиглэсэн хоёр удаагийн төлөвлөгөөт их засварын ажлыг аюул осолгүй бөгөөд амжилттай хэрэгжүүлсэн. Тайлангийн хугацаанд 724.7 мянган тонн баяжмал савлаж, олон улсын зах зээлд нийлүүлээ.

## Ил уурхайн нийт олборлосон материал


(сая тонн)



## Баяжуулах үйлдвэрийн нийт боловсруулсан

ХҮДЭР

(сая тонн)





# Мэргэшсэн ажиллах хүчин

## Удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох

Дэлхийд тэргүүлэх уул уурхайн компанийн хувьд бид боловсон хүчний удирдлагын тогтолцоондоо дэвшилтэт технологийг ашигладаг. 2019 онд хийсэн зарим гол ажил:

- » Улаанбаатар хотод ажилладаг ажилчдын илүү цагийн бүртгэлийг цахимжуулсан.
- » Ажлын газрын тодорхойлолтыг цахимаар олгодог болсон.
- » Сургалтын үнэлгээг цахимжуулснаар бүтээмж нэмэгдсэн.
- » Гэрээт ажилчдын сургалтын удирдлагын системийг (ГАСУС) “Оюу толгой” компани санаачлан Рио Тинто группийн хэмжээнд нэвтрүүлээ. Ингэснээр гэрээт ажилчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, нөөц бололцоогоо зохистой хуваарилахад ихээхэн ач тустай алхам болсон.

## Туршлага, дадлага

- » “Глобал номадс” туршлага судлах ажлыг хоёр удаа зохион байгуулж, оператор, механикчдаас бүрдсэн баг баруун Австрали дахь Рио Тинто төмрийн хүдрийн уурхай, АНУ-ын Солт Лэйк хотын Рио Тинто Кеннекоттын зэсийн уурхайд очиж, мэдлэг туршлага хуримтлууллаа.
- » Дадлагажигч ажилтны эгнээнд таван эмэгтэйг нэмж авснаар эмэгтэй ажилчдын тоог нэмлээ.
- » “Шинэ төгсөгч” хөтөлбөрөөр найман ажилтан шалгаруулж авсны дотор долоон эмэгтэй, нэг эрэгтэй байна. Ийнхүү хөтөлбөрт хамрагдагсдын хүйсийн харьцааг дээшлүүлж, эмэгтэй ажилчдын тоог 35 хувьд хүргэлээ.
- » Гүний уурхайн “Үйлдвэрлэлийн ам”-ны ажиллах хүчийг 3 сарын хугацаанд бүрдүүлэхийн тулд 400 гаруй хүн ажилд авсны 90 гаруй хувь нь монгол ажилчид байна. Энэ явцад ажлын байрны нээлттэй өдөрлөгөөр 15,000 хүн үйлчлүүлж, мэдээлэл авсан ба 40 гаруй үнэлээний төв ажиллуулан ажилчдын сонгон шалгаруулалтыг хийсэн.

## Ирээдүйд чиглэсэн сургалт



2019 онд геотехник болон гүний уурхайн инженер бэлтгэх сургалтыг сайжруулах чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуультай хамтран ажиллах “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав. Мөн Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, “Жи Си Ар Монголиа” болон “Сүбүтэй Майнинг Сервис” компанитай хамтран мэргэжлийн коллежийн 350 төгсөгчийг Австралийн сургалтын стандартын 1 дүгээр зэрэг хангах техник ур чадварыг эзэмшүүлэх зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулан, ажиллаж байна.

“Оюу толгой” ХХК мэргэжлийн боловсрол, сургалтад нийт 67.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийлээ. Нийт 25 оюутныг сургалтын бүтэн тэтгэлэгт, ЕБС-ийн ахлах ангийн 50 сурагчийг “Залуусын хөгжлийн хөтөлбөр”-т хамрууллаа. Алсын хараа, эрхэм зорилгынхоо хүрээнд хүний хөгжилд цаашид тууштай анхаарч ажиллана. Компанийн боловсролын хөтөлбөрт нийт 2,600 гаруй оюутан, сурагч хамрагдаад байна.

# Түншлэгч талуудын хамтын ажиллагаа

Бид нийгэм, байгаль орчинд үзүүлэх аливаа нөлөөг зохистой удирдан, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжилд хувь нэмрээ тууштай оруулж, тогтвортой хөгжлийг бүх боломжоор дэмжин, орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцаагаа бэхжүүлэх эрхэм зорилготой ажиллаж байна. Орон нутгийн харилцаа болон хамтын ажиллагаандаа харилцан итгэлцэл, ил тод байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ, компанийн үнэт зүйлс болон “Бидний ажлын арга барил”-ынхаа зарчмуудыг баримталж хэрэгжүүлдэг.

## “Орон нутгийн түншлэгчидтэй хамтран ажиллах замаар хамтын үнэт зүйлсийг бүтээнэ.”

### Хамтын ажиллагааны гэрээ ба Өмнөговийн тогтвортой хөгжлийн төлөөх үүрэг амлалтын хэрэгжилт

НҮБ-ын Хүн амын сан, Үндэсний статистикийн хороо болон Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааг явууллаа. Энэхүү судалгаа нь 2008- 2018 оны хооронд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд гарсан томоохон өөрчлөлтүүдийг харуулсан. Тухайлбал:

- » Ядуурлын түвшин 2018 онд 11.8 хувь хүртэл буурч, улсын хэмжээнд ядуурлын түвшингээр хамгийн бага үзүүлэлттэй болж байна.
- » Аймгийн ДНБ гурав дахин өссөн.
- » Аж үйлдвэрлэл 36 дахин өссөн.
- » Эхийн эндэгдэл гараагүй.
- » Сургууль завсардсан хүүхдийн тоо 17 дахин буюу 107-оос 6 хүртэл буурсан.
- » Нялхсын эндэгдэл 23-аас 8 болж 0.6 дахин буурсан.

Ийнхүү улсын хэмжээнд Өмнөговь аймгийн ядуурлын түвшин хамгийн бага болж, эхийн эндэгдлийг бүрэн арилгасан бөгөөд нялхсын эндэгдэл эрс буурсан үзүүлэлттэй байна. Ингэснээр тус аймгийн тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд ихээхэн ахиц дэвшил гарлаа. Энэ нь Өмнөговь аймаг, түншлэгч сумд, “Оюу толгой” компани болон бусад талуудын хамтын ажиллагаа тууштай хэрэгжиж ирсний үр дүн юм.

### “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сан (ХДС)

“Оюу толгой” компаниас “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сан (ХДС)-д жил бүр 5 сая ам.долларын санхүүжилт олгодог. “Говийн Оюу” ХДС нь “Оюу толгой” компаниас орон нутгийн гол хамтрагч талуудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах, удирдан зохион байгуулах эрх бүхий бие даасан хуулийн этгээд юм. Сангаас 2015-2019 оны хооронд нийт 22 сая ам.долларын санхүүжилт бүхий үйл ажиллагааг удирдан, хэрэгжүүлсэн байна. Энэ хугацаанд нийгмийн болон хөгжлийн нийт 179 төсөл хэрэгжүүлсэн. 2019 онд хийсэн хөрөнгө оруулалтын үр дүнд орон нутагт 391 ажлын байр шинээр бий болгож, давхардсан тоогоор аймгийн 390,000 иргэн үр өгөөжийг нь хүртээд байна.

“Говийн Оюу” ХДС-ийн санхүүжилтийг хөгжлийн ямар асуудалд, юунд зарцуулахыг компани, орон нутгийн захиргааны төлөөлөл бүхий зөвлөлийн хүрээнд хэлэлцэж, ил тод шийдвэр гаргадаг.

Сангийн үйл ажиллагааны хүрээнд 2019 онд дараах барилга байгууламжийг барьж, хүлээлгэн өглөө. Үүнд:

- » Мандал-Овоо суманд 10 ортой шинэ эмнэлэг
- » Манлай суманд 100 хүүхдийн багтаамжтай шинэ цэцэрлэг
- » Баян-Овоо суманд шинэ уурын зуух

НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан болон ДЭМБ-тай урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуусын эрүүл мэндийг сайжруулах зорилготой 5.01 сая ам.долларын өртөг бүхий хөтөлбөрийг хамтын санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эхийн болон нялхсын эндэгдлийг бууруулах, насанд хүрээгүй охидын жирэмслэлтийг багасгах, нийт иргэдийн дунд гэмтэл бэртийн тоог бууруулах зэрэг эрүүл мэндийн голлох үзүүлэлтүүдийг сайжруулахаар зорьж байна. 2019 онд аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагуудад нийт 100 гаруй төрлийн шаардлагатай тоног төхөөрөмжийг олгож, орон нутгийн эрүүл мэндийн 1000 гаруй мэргэжилтэнг ур чадвар эзэмшүүлэх сургалтуудад хамруулж, 6000 гаруй иргэнд хүрч ажиллажээ.

### Хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих нь

Орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих стратегийг 2019 онд боловсруулсан. Энэхүү стратеги нь Өмнөговь аймаг, Ханбогд сумын хөдөө аж ахуйн бизнес эрхлэгч, бэлтгэн нийлүүлэгч болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн менежментийн ур чадвар болон маркетинг, ложистикийн чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн юм. Уг стратегийн 1-р үе шатны ажлыг гурван талт зөвлөлтэй хамтран Ханбогд суманд хэрэгжүүлж эхэлсэн.

2019 онд хэрэгжүүлсэн гол ажил:

- » Ханбогд дахь Сум дундын малын эрүүл мэндийн төвийн менежментийг Мал эмнэлгийн ерөнхий газарт шилжүүлж, бүрэн хүчин чадлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.
- » Махны чиглэлийн үхэр, хонь үржүүлэх, хүнсний ногоо тарих зэрэг малчдын тогтвортой амьжиргааг дэмжих төслүүд хэрэгжиж эхэлсэн. Энэ хүрээнд малчдын хоршоод идэвх санаачилгатай ажиллаж, төслүүдээ хариуцлагатай хэрэгжүүлж байна.
- » Мал нядалгааны газар, малчдаас нийлүүлэх бүтээгдэхүүний зах зээлийн талаар Ханбогд сумын нийт 285 малчин өрхийг хэлэлцүүлэгт хамруулан, өргөн хүрээний мэдээлэл мэдээлэл хүргэлээ.

### Даланзадгад хот дахь мах боловсруулах үйлдвэр



Даланзадгад хотод шинэ мах боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд хамтарсан санхүүжилт олгож 2019 онд нээлтээ хийв. Энэ нь аймгийн хэмжээнд мах, махан бүтээгдэхүүний химийн болон микробиологийн шинжилгээ хийх баталгаат лаборатори бүхий анхны үйлдвэр юм. Мөн аймгийн хэмжээнд мал ариутгалын төсөл хэрэгжүүлж нийт 5,536 өвөлжөө бууц, 3.5 сая толгой малыг ариутгалд хамруулан 15 суманд мал угаалгын байгууламжуудыг шинээр байгууллаа. Олон жилийн турш хөдөө аж ахуйн салбарыг дэмжих чиглэлээр хийсэн бидний ажлыг үнэлж, Өмнөговь аймаг болон түншлэгч сумдаас “Оюу толгой” компанийг “Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жилийн шилдэг хөрөнгө оруулагч” байгууллагаар шалгаруулсан болно.

### Орон нутгийн эдийн засгийн хөгжил, ажил эрхлэлт, худалдан авах ажиллагааг дэмжих

“Оюу толгой” компани орон нутгийн харьяат ажилчдыг дэмжиж, орон нутгийн ханган нийлүүлэгч болон бизнес эрхлэгчидтэй түншилж, улмаар орон нутгийн хөгжилд оруулах эдийн засгийн үр өгөөжөө нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч ажилладаг. Үүнтэй холбогдож сүүлийн жилүүдэд орон нутгийн хамтрагч талуудтай хийх харилцаа, хамтын ажиллагааны хандлага нөхөн олговороос бүтээлч, бизнес эрхлэх буюу энтерпренёр сэтгэлгээг дэмжих чиглэлд шилжин, төвлөрч ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд:

- » Орон нутгийн ажил эрхлэлт, ханган нийлүүлэлтийн хувь хэмжээг зорьсон түвшиндээ хүргэж ажиллалаа. “Оюу толгой” компанийн үндэсний нийт худалдан авалтын 24 хувь нь Өмнөговь аймгийн аж ахуйн нэгжүүд, нийт ажилчдын 22.5 хувь нь орон нутгийн иргэд байна. Энэ онд Өмнөговь аймгийн Манлай суманд уурхайн баяжмалын уут, нэг удаагийн хамгаалалтын хувцас нийлүүлэх үйлдвэр тус тус ашиглалтад орж, 64 ажлын байр шинээр бий боллоо.
- » Өмнөговь аймгийн засаг захиргаа, “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сан, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (GIZ), хамтран Бизнесийн инноваци, хөгжлийн төвийг Даланзадгад суманд байгууллаа. Энэхүү төвд орон нутгийн мянга гаруй бизнес эрхлэгчид байгаль орчин, эрүүл мэнд, найдвартай байдал, бизнесийн ёс зүй, удирдлага, ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын чиглэлээр мэдлэг мэдээлэл ур чадвараа нэмэгдүүлэх, чадавх бэхжүүлэх сургалтад суралцаж, өөрсдийн эрхэлж буй бизнесээ сайжруулах боломжтой боллоо.
- » ХААН банктэй хамтран хэрэгжүүлж буй “Говийн Оюу” ХДС-ийн “Говийн Оюу – Бизнесийн боломж” жижиг зээлийн хөтөлбөрөөс орон нутгийн 41 бизнес эрхлэгч нарт бизнесийн зээлийн үйлчилгээ үзүүлээд байна.

### Гурван талт зөвлөл – малчдын гомдол шийдвэрлэх гэрээний хэрэгжилт

Гурван талт зөвлөл (ГТЗ) нь малчдын гомдол барагдуулах гэрээнүүдэд тусгагдсан ажлуудыг бүрэн гүйцэд зохион байгуулж, хэрэгжүүлэх зорилготой. Энэ хүрээнд малчдын амьдрах орчин, хүрээлэн буй орчин /бэлчээр, ус, байгаль орчин гэх мэт/-той холбоотой аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, холбогдох гомдол, санал, санаачилгын талаар санал, зөвлөмж, шийдвэр гаргах эсвэл шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд мэдээлэх зэрэг үндсэн үүргүүдийг гүйцэтгэн ажилладаг. Уг зөвлөл нь нийт 15 гишүүнтэй бөгөөд үүнд орон нутгийн малчдын төлөөлөл, Ханбогд сумын засаг захиргааны төлөөлөл, “Оюу толгой” компанийн төлөөлөл тус тус байдаг.

Зургаан жилийн турш Эрх зүйн хэрэгжилт, нийцэл, омбудсмений газрын (CAO) эвлэрүүлэн зуучлалтайгаар хэрэгжүүлсэн маргаан, гомдлыг шийдвэрлэх ажиллагааг хаах шийдвэрийг ГТЗ-өөс гаргаж, туршлага хуваалцах арга хэмжээг Улаанбаатар хот болон Ханбогд суманд 2019 оны 3-р сард зохион байгууллаа. Энэхүү маргаан шийдвэрлэх ажиллагаа амжилттай шийдэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл бол маргаанд оролцогч талууд асуудлаа хамтран шийдвэрлэхийн төлөө тууштай хамтран ажилласан явдал юм. Мөн нээлттэй харилцан яриа, хэлэлцээ өрнүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр хамтын ажиллагаа, харилцан итгэлцлээ бэхжүүлж чадсан.

Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаа нь цаашид “Малчдын гомдол барагдуулах гэрээ”-ний хэрэгжилтийг хангахад чиглэж байгаа ба гэрээнд заасан үүрэг амлалтын хэрэгжилтийг хангах, ялангуяа тогтвортой амьжиргааг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гоц анхаарч ажиллаж байна.

2019 оны 6-р сарын байдлаар малчдын гомдол барагдуулах гэрээнд заасан ажлууд 36 хувийн хэрэгжилттэй, урт болон дунд хугацаанд хэрэгжиж буй ажил 47 хувь, хэрэгжилтийг хангах төлөвлөлтийн шатандаа байгаа ажил 17 хувьд хүрээд байна.

### **Орон нутгийн харилцаа, хамтын ажиллагаа**

Нутгийн талуудтай үр бүтээлтэй, урт хугацааны хамтын ажиллагааг өрнүүлж ирсэн. Орон нутгийн удирдлага, ард иргэдтэй бүх түвшинд тогтмол харилцаж, компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн мэдээллийг жил бүрийн нээлттэй өдөрлөгийн үеэр танилцуулдаг уламжлалтай. Ханбогд, Баян-Овоо, Манлай сумын засаг захиргаатай хамтран нээлттэй өдөрлөгийн арга хэмжээг 2019 оны 10 сард “Бид нэг гэр бүл” сэдвийн дор хамтран зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр “Оюу толгой” компанийн уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэлээ. Нээлттэй өдөрлөгт хамрагдсан иргэдээс авсан санал асуулгад оролцогчдын 88 хувь нь өдөрлөгийн ажиллагааг эерэгээр үнэлсэн байна.

### **Олон улсын стандартын хэрэгжилт**

Оюу толгой төслийн санхүүжүүлэгчийн зүгээс хийгддэг жил тутмын шалгалт хийгдсэн. Энэхүү аудитын шалгалтын дүнгээр компанийн орон нутгийн харилцааны үйл ажиллагаа нь санхүүжүүлэгч талын шаардлагыг бүрэн хангаж байгааг баталгаажуулсан. Бид орон нутгийн харилцааны чиглэлээр ийнхүү олон улсын стандартад нийцүүлж ажиллахаас гадна нийт оролцогч талуудтай идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлэхийн төлөө тууштай чармайн ажиллаж байна. Бүх аудитын тайлан олон нийтэд нээлттэй бөгөөд компанийн цахим хуудаснаас үзэх боломжтой.

### **Бүсийн хөгжил**

Орон нутаг, бүс нутаг, улсын хэмжээнд тогтвортой хөгжлийн урт хугацааны бодлого, стратегийг уялдуулахад чиглэсэн олон талыг оролцоог хангасан хэд хэдэн арга хэмжээ, уулзалтыг зохион байгууллаа.

Тухайлбал:

- » “Уурхайн бүсийн дагуул хотын хөгжлийн асуудал” сэдэвт уулзалт семинарыг зохион байгуулж, уул уурхайн орчмын хот суурин газрыг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл сорилт, боломжийн талаар хэлэлцлээ. Энэ арга хэмжээнд Өмнөговь аймаг, Ханбогд сумын удирдлагууд, Барилга, хот байгуулалтын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар, Үндэсний статистикийн газар, НҮБ-ын Хүн Амын Сан, элчин сайдын яамдууд, олон улсын санхүүгийн байгууллагууд, уул уурхайн компанийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагууд, Өмнөговь аймгийн иргэд оролцсон.
- » Ханбогд сумын Мастер төлөвлөгөөг шинэчлэх ажлыг гол талуудтай хамтран ярилцсаны үндсэн дээр “Оюу толгой” компани санхүүжүүлж байна. 2020 оны 6-р сард бэлэн болох энэхүү төлөвлөгөө нь Ханбогд сумыг тогтвортой байдлаар цаашид хөгжүүлэх, орон нутгийн иргэд, уурхайн ажилчдад тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд нэн ач холбогдолтой юм.
- » Өмнийн говийн бүсийн хөгжлийн чиг баримтлалыг “Оюу толгой” компанийн санхүүжилтээр Үндэсний хөгжлийн газар болон Монгол Улсын их сургуулийн судалгааны баг боловсруулсан ба 2020 оны эхээр Монгол Улсын Засгийн газар хэлэлцэх юм.

---

### **ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХОЛБООТОЙ ХАМТРАВ**

**“Бид сүүлийн 9 жил оёдоор дагнан бизнес эрхэлж, хөгжлийн бэрхшээлтэй найман иргэнийг ажлын байраар хангалаа. Бодит амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнх нь амьдралын боломж тааруу амьдардаг. Оёдлын бизнесээ явуулах, цаашлаад өргөжүүлэхэд даавуун материал дээр дардас гаргадаг төхөөрөмж бидэнд маш их хэрэгцээтэй байсан. 2019 он бидэнд олон талаар ээлтэй сайхан жил болж өнгөрлөө. Учир нь “Оюу толгой” ХХК манай холбоонд нэн чухал байсан төхөөрөмжийг хандивлаад зогсохгүй, цаашид тус компанид даавуун тор ханган нийлүүлэх гэрээ байгуулсан. Энэ нь манай байгууллагад томоохон өөрчлөлт авчраад зогсохгүй, хөгжлийн бэрхшээлтэй хоёр иргэнийг нэмж ажилд авч, бизнесээ цаашид өргөжүүлэх үүд хаалгыг нээсэн сайхан үйл явдал боллоо.”**






## Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дэмжих төсөл

Монгол Улсад жил бүр зам тээврийн ослоос үүдэн 500 гаруй хүн амь насаа алдаж, хэдэн мянган хүн гэмтэж бэртдэг бөгөөд цаг бусаар хүний амийг авч оддог хамгийн том шалтгаан хэвээр байна. Зам тээврийн аюулгүй байдлын талаарх ойлголтыг олон нийтэд хүргэх, цаашлаад хүний эрүүл мэнд, амь насыг авран хамгаалах үүднээс Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), Мобиком корпорацитай урт хугацааны түншлэл бий болгов. Бид хамтдаа хоёр удаагийн нөлөөллийн аяныг орон даяар амжилттай зохион байгуулснаас гадна Чойрын замд хурд хэмжигч байршуулахад дэмжин ажиллаа.



### “Яараад яахав дээ” нөлөөллийн аян

Зам тээврийн осол аялал зугаалга их болдог зуны улирал буюу зургаагаас есдүгээр сарын хооронд хамгийн их гардгийг харгалзан, орон нутгийн замд хурд хэтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү аяныг зохион байгуулсан. Аяны үр дүн (өмнөх оны мөн үетэй харьцуулахад):






Олон нийтэд хүрсэн байдал, гарсан эерэг үр дүн зэрэгт үндэслэн тус аян маань “Unplug 2019” арга хэмжээнээс “Шилдэг санаачилга” шагналыг хүртлээ.



### “Дураараа биш дүрмээрээ” нөлөөллийн аян


Суурин газрууд тэр дундаа Улаанбаатар хотод зам тээврийн дүрэм журмыг дагаж мөрдүүлэхтэй холбогдуулан энэхүү аяныг есдүгээр сараас арван нэгдүгээр сар хүртэл зохион байгуулсан нь олон нийтэд эерэгээр хүрч, зам тээврийн ослыг Улаанбаатар хот төдийгүй орон нутагт ч тодорхой хэмжээнд бууруулав. Аяны үр дүн (өмнөх оны мөн үетэй харьцуулахад):



### Чойр хотод суурилуулсан хурд хэмжигч

Монгол Улсын зүүн өмнөд хэсэгт орших, зам тээврийн осол гаралтаар өндөрт тооцогддог Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Дорноговь аймгийн Сайншанд сум дахь замын цагдаагийн постуудад иж бүрэн хяналтын систем суурилууллаа. Энэхүү хяналтын системийг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хурд хэтрүүлсэн эсэхийг шалгах, татвар даатгал, оношилгоондоо хамрагдсан эсэхийг хянаж, илэрсэн зөрчилд арга хэмжээ аван, аюулгүй байдлыг хангуулах зэргээр ашиглах юм.

Монгол Улсад зам тээврийн аюулгүй байдлыг хангаж, замын хөдөлгөөний соёлыг төлөвшүүлэн, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Оюу толгой” компани ЦЕГ-тай урт хугацаанд хамтран ажиллана.







# Стратегийн хөгжил

## Гүний уурхай

Гүний уурхайн төслийн хувьд 2019 онд багагүй сорилт тулгарсан боловч өндөр бүтээмжтэй жил болж өнгөрлөө. Гүний уурхайн төслийн баг хэд хэдэн чухал дэд бүтцийн барилгын олон чухал ажлыг дуусгаж, нэвтрэлтийн ажилд дорвитой ахиц гаргав.

2019 онд зах зээлд мэдээлэгдсэн гүний уурхайн геотехникийн хүндрэлүүдийг шийдвэрлэхийн тулд уурхайн зураг төслийг нарийвчлан нягталж, шинэчлэх ажил үргэлжилж байна. Ингэснээр гүний уурхайн урт хугацааны аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангаж, компанид болон улс оронд ирэх үнэ цэнийг тогтвортой бий болгох юм. Уурхайн шинэчилсэн зураг төсөл 2020 оны эхний хагаст бэлэн болох ба нарийвчилсан үнэлгээг 2020 оны хоёрдугаар хагаст танилцуулахаар төлөвлөж байна.

### Ажиллах хүчин

2019 онд гүний уурхайн барилга бүтээн байгуулалтанд нийт 19 сая хүн/цаг ажилласан. Ингэснээр 2016 оноос хойш гүний уурхайн бүтээн байгуулалтад нийт 50 сая гаруй хүн/цаг ажил гүйцэтгэсэн байна. Бүх гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт (БГБД) 2019 онд 0.21 байсан нь зорилтот түвшин болох 0.26-аас давж хэрэгжсэн байна. Гүний уурхайн бүтээн байгуулалтын төсөл эхэлснээс хойш БГБД-ийн үзүүлэлт 0.26 байна. 2019 оны 12 дугаар сард нийт төслийн хэмжээнд огт осол зөрчилгүй ажилласан. Аюулгүй байдлын мэдлэг туршлагаа бусадтай хуваалцах зорилготой “Аюулгүй ажиллагааны элч төлөөлөгч” санаачлагын хүрээнд мэргэжлийн байгууллагууд болон иргэдийн бүлэгт өндөр эрсдэл, манлайлын сургалтуудыг явуулж, 5,500 гаруй хүнийг хамруулсан.

Гүний уурхайн ажиллах хүчний 88-92 хувийг монгол ажилчид бүрдүүлж, нийт 37 орны мэргэжилтнүүд хамтдаа ажиллаж байна. Төслийн явц эрчимжиж, багц ажлууд шувтран, бүтээмж сайжруулах төслүүд хэрэгжсэнээр ажилчдын тоо 8,037 -аас 7,209 болж буурсан. Гүний уурхайн ажилчдыг бэлтгэхэд дараах байдлаар анхаарч байна. Үүнд:

- » Залгамж халаа төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, гадаад мэргэжилтний орон тоог дотоод мэргэжилтнээр шилжүүлэн бүрдүүлэх, ажилтныг чадавхжуулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- » Гүний уурхайн төсөлд шинээр ирсэн бүх ажилчдыг аюулгүй ажиллагааны дүрэм журмууд, манлайлал, бизнесийн сайжруулалт мөн тухайн ажлын байрны онцлогийг хамарсан өргөн цар хүрээтэй сургалтын хөтөлбөрүүдэд хамруулсан.
- » Давхардсан тоогоор нийт 37,924 ажилтныг 4,243 сургалтад хамруулсан.
- » Гүний уурхай төслийн “Хамтдаа” соёлын хөтөлбөрт 5,700 оролцогчийг сургасан.
- » “Үйлдвэрлэлийн ам”-ны системийг ажиллуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн 300 гаруй гэрээт ажилтныг Оюу толгой компани руу шилжүүлэн авсан.
- » Гүний уурхайн чиг баримжаа олгох сургалт, Ноцтой эрсдэлийн удирдлагын сургалтыг виртуал бодит байдлын (VR) 360° видеоогоор шинэчилснээр уурхайн өргөтгөл, холбогдох процессын өөрчлөлтүүдийг тусгах агуулга бэлтгэж, ашиглахад хэмнэлттэй бөгөөд үр дүнтэй ажил болсон.

### Мөнгөн хөрөнгө

Гүний уурхайн төслийг инженер, худалдан авалт болон барилга бүтээн байгуулалтын туршлагатай мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр Оюу толгойн баг удирддаг. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 4.3 тэрбум ам. долларын худалдан авалтын гэрээ хийгдсэний 2.9 тэрбум ам.долларын гэрээг дотоодын ханган нийлүүлэгчидтэй хийсэн нь зорилтот дүн 1.4 тэрбум ам. доллар (2016 он), мөн шинэчилсэн дүн 2 тэрбум ам. долларыг (2018) давсан үзүүлэлттэй ажилласан. Шууд гэрээний дүнгээр нийт 0.9 тэрбум ам.доллар олон улсын ханган нийлүүлэгчдэд олгогдсон байна.

Худалдан авах ажиллагаа, гэрээний багцуудаар дамжуулан дотоодын ханган нийлүүлэгчдэд зарцуулсан хувь Төслийн худалдан авах ажиллагааны нийт дүнгийн 88 хувийг эзэлж байна.

	Мөнгөн хөрөнгө
<b>2019</b>	1,183 сая ам.доллар*
<b>Төсөл эхэлснээс өнөөг хүртэл</b>	3.4 тэрбум ам.доллар*

\* Энэ дүнд менежментийн үйлчилгээний төлбөрийг оруулж тооцоогүй тул уг тайлангийн 6, 16 болон 17 дахь хуудасны санхүүгийн хэсэг дэх дүнгээс зөрүүтэй болно.

2019 оны гол үр дүн:

#### **Барилгын ажил**

- » “Үйлдвэрлэлийн ам”-ны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны аравдугаар сард дуусгасан бөгөөд энэхүү тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан Уул уурхайн сайд болон бусад түншлэгч талуудтай хамтарч ёслолын арга хэмжээ зохион байгуулав. Энэхүү байгууламжийг барьж гүйцэтгэхэд дотоодын 50 орчим аж ахуйн нэгж, 2,500 ажилчин аюул осолгүйгээр 2.6 сая гаруй хүнцаг ажиллав. Уг ам нь газрын гадаргаас доош 1,284м, дээш 96м өндөр ба 10м-ийн диаметр бүхий байгууламж юм. Нийт өндөр нь 1.3 км буюу Улаанбаатар хот дахь Шангри-ла зочид буудлын барилгыг 15 давхарласантай тэнцэнэ (газар доор 14, газар дээр 1). Түүний бүтээгдэхүүний өргүүр нь дэлхий дээрх хамгийн том “Коепе буюу үрэлтийн хүчний өргүүрийн систем бөгөөд тус бүр нь 60 тонны даацтай хоёр хөнөгтэй. “Үйлдвэрлэлийн ам”-ны хүн тээврийн өргүүр (клеть) нь нэг эргэлдээ 300 хүнийг тээвэрлэх багтаамжтай.
- » Гүний уурхайн ажиллагаа, ажилчид болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хянах зориулалттай дэвшилтэт технологиор тоноглогдсон хяналтын танхим бүхий “Чандмань” захиргаа, үйлчилгээний төвийг барьж ашиглалтад оруулав. Энэхүү барилга нь гүний уурхайн ажилтнуудад зориулсан шүршүүр, хувцасны өрөө, хувийн хамгаалах хэрэгслийн агуулах, зоогийн газар, хурлын танхим бүхий нийт 13,570 метр квадрат талбайтай хоёр давхар барилга юм.
- » Дулааны төв станцыг 58МВт-аар өргөтгөж, хүчин чадлыг нь 72МВт-аас 130МВт-д хүргэсэн.

#### **Инженерчлэл**

- » Ерөнхий инженерчлэлийн ажлын гүйцэтгэл нь үндсэндээ төгсгөлийн шатандаа орсон. Инженер техникийн ажил нь одоо бэлтгэн нийлүүлэгчдийн гэрээний гүйцэтгэлийг дүгнэж хаах, улмаар үйл ажиллагааны бэлэн байдлыг хангахад төвлөрч байна.

#### **Уурхайн малталт нэвтрэлт**

- » Хөндлөн нэвтрэлтийн хөдөлмөрийн бүтээмж нь сар тутмын төлөвлөгөөнөөс тогтмол давж ирсэн бөгөөд 2019 оны III, IV улиралд уг бүтээмж 40 хувиар ахисан дүнтэй байна. Төслийн хугацааны нийт хөндлөн нэвтрэлтийн хэмжээ 32,925 экв.м-т хүрсэн бөгөөд 2019 онд 14,606 экв.м\*-н гүйцэтгэлтэй байна.

#### **Налуу амны нэвтрэлт**

- » Налуу амны нэвтрэлт эхэлснээс хойш 8,765 экв.м-т хүрч, 2019 онд нийт 3,468 экв.м\* ахижээ.

#### **Анхдагч бутлуур**

- » Анхдагч бутлуур 1-ийн газар шорооны ажил явагдаж буй бөгөөд хоёрдугаар түвшний бутлуурын хана ба ус тунгаагуурын хануудыг амжилттай цутгаж дуусгасан байна.



\*Нийт 12 сарын тохируулах бичилтийн дүн болно.

## Эрчим хүч

### Оюу толгойн эрчим хүчний хэрэгцээ

Оюу толгой нь цахилгаан эрчим хүчний хувьд өндөр хэрэглээтэй төсөл юм. Оюу толгойн гүний уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд төслийн нийт эрчим хүчний хэрэглээ 250 МВт орчим болох бөгөөд энэ нь улсын эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон тохиолдолд нийт чадлын 20 хувьтай дүйцэхүйц байна.

### Эрчим хүчний хэрэглээний гол хүчин зүйлс:

- » Газрын гадаргаас 1,200 метрийн гүнд ажиллах уурхайчдын ажил, тэдний ажиллах орчин (агаар, ус, гэрэл, хоол унд гэх мэт) нь цахилгаан эрчим хүчнээс бүрэн хамааралтай байна.
- » Уурхайн үйл ажиллагааг аюулгүй явуулж, блокчлон олборлолтыг тасралтгүй ажиллуулахад найдвартай цахилгаанаар хангах нь нэн шаардлагатай.
- » Цахилгаан эрчим хүчний зардал нь цалингийн зардлын дараа хоёрдугаарт орох үйл ажиллагааны зардлын томоохон бүрдэл хэсэг юм.

Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу Оюу толгойн эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангахаар "Оюу толгой" ХХК тууштай ажиллаж байна. Энэ хүрээнд Оюу толгойн төдийгүй улс орны эрх ашгийг хангах цахилгаан эрчим хүчний оновчтой шийдлийг олохоор "Оюу толгой" ХХК-ийн зүгээс Засгийн газартай нягт хамтран ажилласаар ирсэн билээ. 2018 оны 12-р сард "Оюу толгой" ХХК болон Засгийн газар хооронд Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай (ЭХЭҮЗГ) гэрээ байгуулсан. Энэ гэрээнд Тавантолгой нүүрсний ордод тулгуурлан нүүрсний цахилгаан станцыг барьж байгуулах ерөнхий бүтэц, холбогдох зохицуулалтыг тодорхойлж өгсөн. Дэлхийн цаг уурын өөрчлөлт, нүүрсний цахилгаан станцын санхүүжилт олон улсын хэмжээнд хомстсон, үүнтэй холбоотой Оюу толгой төслийн зардлын өсөлт, улмаар хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах хугацаа хойшлох зэрэг сорилтууд тулгарч байгаа хэдий ч "Оюу толгой" ХХК нь гэрээний дагуу нүүрсний цахилгаан станц барьж байгуулахаар хүчин чармайлт гарган ажиллаж байна.

### 2019 онд гарсан зарим ахиц:

- » Эрчим хүчний зохицуулах хорооноос шаардагдах тусгай зөвшөөрлүүдийн сунгалтуудыг хийсэн.
- » "Түлхүүр гардуулах" нөхцөл бүхий инженерийн ажил, худалдан авалт, барилга угсралтын (ЕРС) гэрээний уралдаант сонгон шалгаруулалтын ажиллагааг хэрэгжүүлэн дуусгаж, гэрээ байгуулахад бэлэн болов. Засгийн газраас холбогдох зөвшөөрлийг олгох, мөн "Оюу толгой" ХХК-ийн ТУЗ-ийн шийдвэр гарсан тохиолдолд 2020 оны 1-р хагаст багтаан тус инженерийн ажил, худалдан авалт, барилга угсралтын (ЕРС) гэрээг байгуулах төлөвлөгөөтэй байна.
- » Техникийн судалгааны гол ажлууд ахицтай явагдаж байна:
  - » Төслийн Техник эдийн засгийн үндэслэлийг бэлтгэж дуусгасан бөгөөд 2020 оны эхээр Эрчим хүчний яаманд хүргүүлж, тус яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.
  - » Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг бэлтгэж дуусгасан бөгөөд 2020 оны 1-р хагаст багтаан олон нийтэд танилцуулна.
  - » Диспетчерийн үндэсний төвтэй байгуулсан гэрээний дагуу эрчим хүчний нэгдсэн системээс цахилгаан эрчим хүчээр хангах үеийн горимын тооцоог хийж эхэлсэн ба 2020 оны хоёрдугаар улиралд дуусна.





## Маркетинг ба борлуулалт

Тайлангийн хугацаанд зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэхэд анхаарч, гэрээ хэлцэл байгуулахдаа компанийн ТУЗ-өөс баталсан стратегийг хэрэгжүүлж ажиллаж ирэв. Зэсийн баяжмалын нийлүүлэлтэд томоохон хувь эзлэх спот болон урт хугацааны борлуулалтын гэрээг маркетингийн багийн зүгээс худалдан авагчидтай хэлэлцэн тохирсон. Ингэснээр борлуулалтын үнийн дүн болон худалдан авагчдын тоог нэмэгдүүлэх, маркетингийн бүтцийг нь тэнцвэржүүлэх болон гүний уурхайгаас гарах бүтээгдэхүүнийг зах зээлд байршуулж, гаргах боломж нээгдсэн болно.

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Баяннуур аймагтай 2012 онд байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд “Оюу толгой” компани “Фейшанг” зэс хайлуулах үйлдвэртэй нягт хамтран ажиллаж буй бөгөөд 5 жилийн гэрээний хоёр дахь жилийг амжилттай дуусгасан дүнтэй байна.







# Төлөөлөн удирдах зөвлөл

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

### Галсангийн Батсүх

2010 оны зургаадугаар сард томилогдсон

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

### Армандо Торрес

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал  
2017 оны тавдугаар сард томилогдсон

### Цэвэгмидийн Түмэнцогт

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2018 оны зургаадугаар сард томилогдсон

### Арнауд Суарат

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2018 оны есдүгээр сард томилогдсон

### Нацагийн Багабанди

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2016 оны есдүгээр сард дахин томилогдсон

### Цэрэнгийн Сүхбаатар

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2019 оны дөрөвдүгээр сард томилогдсон

### Элиас Скафидас

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2018 оны есдүгээр сард томилогдсон

### Улф Куэлман

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2018 оны есдүгээр сард томилогдсон

### Люк Колтон

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2018 оны дөрөвдүгээр сард томилогдсон

# Гүйцэтгэх удирдлагын баг

## **Армандо Торрес**

Гүйцэтгэх захирал

2017 оны тавдугаар сард томилогдсон

## **Марко Пирес**

Гүний уурхайн төслийн захирал

2016 оны гуравдугаар сард томилогдсон

## **Тим Экерсли**

Уурхайн үйл ажиллагаа хариуцсан захирал

2018 оны нэгдүгээр сард томилогдсон

## **Дашнямын Амарбаясгалан**

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал

2014 оны аравдугаар сард томилогдсон

## **Шуркагийн Байгалмаа**

Стратегийн орон нутгийн төслүүд хариуцсан ерөнхий менежер

2019 оны зургаадугаар сард томилогдсон

## **Пол Мюллинс**

Санхүү хариуцсан захирал

2017 оны тавдугаар сард томилогдсон

## **Лаура Томас**

Хүний нөөцийн асуудал хариуцсан ерөнхий менежер

2017 оны тавдугаар сард томилогдсон

## **Жамбын Сүнжидмаа**

Хамтын ажиллагаа, мэдээлэл харилцаа хариуцсан ерөнхий менежер

2018 оны есдүгээр сард томилогдсон

## **Маррэй Сварипа**

ЭМААБОАБ-ын асуудал хариуцсан ерөнхий менежер

2017 оны зургаадугаар сард томилогдсон

## **Цэрэвсүрэнгийн Цэрэнхүү**

Компанийн Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

2010 оны наймдугаар сард томилогдсон

# ТУЗ ба Хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

## **Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Хувьцаа эзэмшигчдийн 16-р хурал – 2019 оны 4-р сарын 25 (жил тутмын ерөнхий хурал)

## **Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал**

36-р хурал – 2019 оны 3-р сарын 6

37-р хурал – 2019 оны 6-р сарын 12

38-р хурал – 2019 оны 9-р сарын 4

39-р хурал – 2019 оны 12-р сарын 12

## **Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал**

Ээлжит бус 27-р хурал – 2019 оны 2-р сарын 12 ба 25

Ээлжит бус 28-р хурал – 2019 оны 8-р сарын 22

Ээлжит бус 29-р хурал – 2019 оны 10-р сарын 23, 11-р сарын 1 ба 11

## **Аудит, санхүүгийн хороо (АСХ) -ны хурал**

АСХ-ны 35-р хурал – 2019 оны 3-р сарын 5

АСХ-ны 36-р хурал – 2019 оны 6-р сарын 11

АСХ-ны 37-р хурал – 2019 оны 9-р сарын 3

АСХ-ны 38-р хурал – 2019 оны 12-р сарын 11

## **Үйл ажиллагааны хороо (ҮАХ) -ны хурал**

ҮАХ-ны 32-р хурал – 2019 оны 3-р сарын 5

ҮАХ-ны 33-р хурал – 2019 оны 6-р сарын 11

ҮАХ-ны 34-р хурал – 2019 оны 9-р сарын 3

ҮАХ-ны 35-р хурал – 2019 оны 12-р сарын 11

## **Хүний нөөц, сургалтын хороо (ХНСХ) -ны хурал**

ХНСХ-ны 34-р хурал – 2019 оны 3-р сарын 5

ХНСХ-ны 35-р хурал – 2019 оны 6-р сарын 11

ХНСХ-ны 36-р хурал – 2019 оны 9-р сарын 3

ХНСХ-ны 37-р хурал – 2019 оны 12-р сарын 11

## **Хамтын ажиллагааны хороо (ХАХ) -ны хурал**

ХАХ-ны 7-р хурал – 2019 оны 3-р сарын 5

ХАХ-ны 8-р хурал – 2019 оны 6-р сарын 11

ХАХ-ны 9-р хурал – 2019 оны 9-р сарын 3

ХАХ-ны 10-р хурал – 2019 оны 12-р сарын 11





